



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.09 № 102

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар И баримтгүй гүйлгээ хийсэн, босго үнээс дээш худалдан авалтад тендер зарлаагүй, орон тоо илүү ажиллуулж зөвлөхийн цалин олгосон, сахилгын шийтгэлтэй ажилтан урамшуулал олгосон, албан томилолт илүү тооцож олгосон, ажлаас чөлөөлөгдсөн орлогч нарт тэтгэмж олгосон, засаг даргын нөөц хөрөнгөөр жимс бэлэг, хандив тусламж, шагналд зарцуулсан, албан томилолтгүйгээр шатахуун зарцуулсан, удирдлагын буруугаас цалингийн нөхөн олговор олгосон, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг нийт 723, 539.3 мянган төгрөгийн зөрчил АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын онцолсон хэсэг

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 35.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 4,292.1 сая төгрөгийн хөрөнгийн хүлээж зөвшөөрч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилгын 23 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийн дундаж 92.9 хувьтай байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.ЭРДЭНЭБАТ ТАНАА

0702000350

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	257.8	295.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,252.5	6,431.6
Нийт хөрөнгийн дүн	2,510.4	6,727.5
Нийт өр төлбөрийн дүн	1.7	0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,508.6	6,727.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,510.4	6,725.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	4,059.7	8,379.1
Үйл ажиллагааны зардлын дүн	4,066.6	4,111.9
Үйл ажиллагааны үр дүн	-6.9	4,267.1
Үйл ажиллагааны бус үр дүн	36.3	48.3
Үйл ажиллагааны нийт үр дүн	-43.3	4,218.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,551.9	2,508.6
Тайлант оны үр дүн	-43.3	4,218.9
Эцсийн үлдэгдэл	2,508.6	6,727.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,059.7	3,925.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,009.2	3,890.3
Үйл ажиллагааны ЦМГ	30.1	35.4
Хөрөнгө оруулалтын ЦМГ	33.2	35.4
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-3.1	0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
Урсгал зардал	2,774.8	2,669.9
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,774.8	2,667.8
Улсын төсвөөс санхүүжих		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000.0	24.3

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 579.1 сая төгрөгийн алдаа¹, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 579.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан, Үүнээс нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 109.2 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Аймгийн ЗДТГ-ын бүртгэлд бүртгэлтэй 424.9 сая төгрөгийн өртөгтэй барилгыг Улсын бүртгэлийн хэлтэст, 13.4 сая төгрөгийн үнэ бүхий автомашиныг Шүүх шинжилгээний хэлтэст шилжүүлэх Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр ирээгүй байхад данс бүртгэлээс хассан байна. Мөн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 10.4 төгрөгийн үндсэн хөрөнгөөр бараа материалын тайланд орлого авсан, Шүүхийн шийдвэрийн нөхөн олговрын 0.4 мянган төгрөгийн НДШ тайлагнаагүй нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" заалтыг зөрчсөн байна.
- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 109.2 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 723.5 сая төгрөгийн зөрчил²илэрснээс, 21.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 702.5 төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 11 заалт зөрчил бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, хариуцлага тооцох 1 заалттай албан шаардлага хургуулсан.

Төлбөрийн акт

- Аймгийн ЗДТГ-т Засаг даргын зөвлөхийн 2 орон тоо илүү ажиллуулан 6.0 сая төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т "Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно", гэж заасан, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Албан томилолтын зардал 1.5 сая төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгосон" гэж заасан, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Аймгийн засаг даргын орлогчид ажлаас чөлөөлөгдсөний тэтгэмж 10.9 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," МУЗЗНДНТУТХуулийн 78 дугаар зүйлийн 78.1-т "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно"; гэж заасан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

- Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2.6 сая төгрөгийн бэлэг, жимс худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.2.6-т /үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага/, санхүүжилт гаргахгүй байх; 15 дугаар зүйлийн 15.1.3-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"/, 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; гэж заасан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Албан шаардлага

- Тээвэр шатахууны зардалд 87.7 сая төгрөгийн төсөв батлагдсан хэдий ч худалдан авах ажиллагаа зарлаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Монгол улсын засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн тогтоох тухай" нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Шилэн дансны цахим сайтад байршуулах таван саяас дээш 1,723.1 сая төгрөгийн 109 гүйлгээнээс 238.7 сая төгрөгийн 19 гүйлгээг мэдээлээгүй, 61.3 сая төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.4-т таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, 6.4.5-т цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Сахилгын шийтгэлтэй ажилтанд 0.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-т /Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно/ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас хандив тусламж, шагналд нийт 54.9 сая төгрөгийн хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр хөрөнгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.2.6.үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх; 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах";, 12 дугаар зүйлийн 12.1.4-т/хуулиар зөвшөөрөөгүй бусад/ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Албан томилолт удирдамжгүйгээр 20.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, томилол ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Удирдлагын буруутай шийдвэрийн улмаас цалингийн нөхөн олговорт 9.1 сая төгрөгийг төлж төсөв хохироосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх

үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Байгууллагын удирдах ажилтнуудаас цай, чихэр кофены зардалд 2.2 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т/хуулиар зөвшөөрөөгүй бусад/ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч тоолуур ашиглаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах, нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Ажилчдын амралтыг биеэр эдлүүлэх нөхцөлийг хангаж ажиллаагүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т /Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно/, 99.2-т Ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулснаас хойш зургаан сар ажилласан бол түүнд ээлжийн амралт эдлэх эрх үүснэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Өмнөх аудитын шийдвэрийг үлдэгдэл 31.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 287.4 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжүүлж ажиллаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах; Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх"; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана", нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Аудитаар зардлыг түүвэрчлэн үзэхэд: НҮБ-ийн санхүүжилтээр 4 хөтөлбөрт 313.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч гэрээний хугацаа дууссан ч гэрээг дүгнээгүй, төсвийн төлөөлөгч/зохицуулагч/ нь өөрийн хамаарал бүхий этгээдийн дансанд 3.5 сая төгрөгийг, мөн гэрээ байгуулаагүйгээр иргэний дансанд 126.6 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн, сургалтын зардалд 36.1 сая төгрөгийг зарцуулсан хэдий ч ихэнх зардалд тоо, ширхэг юу авсан нь тодорхойгүй, нярвын тайлан байхгүй шууд зардлаар тайлагнасан.

5.4 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-т "Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон

хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай"-ийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэ н		Үүнээс				Зөв лө мж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн	1	160,383.1	-	-	-	-	1	109,165.2	1	51,217.9	-	-
Зардлын эдийн засгийн ангилал зөрүүтэй тайлагнасан	1	449,214.0	-	-	-	-	1	449,214.0	-	-	-	-
Хэлбэлзэл зөрүүтэй	1	20,685.0	-	-	-	-	1	20,685.0	-	-	-	-
Дүн	3	630,282.10	-	-	-	-	3	579,064.2	1	51,217.9	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

И з э т н ф л	Үүнээс
---------------	--------

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтн ы тоо	Тоо	Дүн
Зөвлөхийн цалин олгосон	1	6,000.0	1	6,000.0								
Сахилгатай ажилтанд урамшуулал олгосон	1	926.5			1	926.5						
Албан томилолт илүү	1	1,472.0	1	1,472.0								
Ажлаас чөлөөлөгдсөн орлогчид тэтгэмж олгосон	1	10,927.0	1	10,927.0	1	10,927.0						
Нөөц хөрөнгөнөөс бэлэг, жимс худалдан авсан	1	2,634.9	1	2,634.0								
Нөөц хөрөнгийн зардлаас хандив, тусламж шагналд зарцуулсан	1	54,924.2			1	54,924.4						
Албан томилолт удирдамжгүйгээр шатахуун зарцуулсан	1	20,309.9			1	20,309.9						
Удирдлагын буруутайгаас цалингийн нөхөн олговор олгосон	1	9,127.7			1	9,127.7						
Байгууллагын удирдах ажилтнуудад цай кофе үнэ	1	2,199.6			1	2,199.6						
Амралтын цалин биеэр эдлүүлэх	1				1							
Өмнөх аудитын шийдвэр хэрэгжүүлээгүй	1								1			
Дүн	11	108,522.8	4	10,106.0	7	98,415.2			1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой								
Шилэн дансанд мэдээллийг дутуу мэдээлсэн	1	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Тод дэвсгэр бүхий дугаар ашиглаагүй	1	-	-	-			1	
Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй.	1	-	-	-	1	-	-	-
Худалдан авах ажиллагаа зарлаагүй	1	87,000.0	-	-	1	87,000.0	-	-
Хяналт шалгалт хийх	1	476,099.4	-	-	1	476,099.4	-	-
Дүн			-	-	2	563,099.4	1	-
Нийт дүн	5	563,099.4						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	0	1	-	-